



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 06

Мандалговь

Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны албанд хавсралтын дагуу өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 9,128,900 /есөн сая нэг зуун хорин найман мянга есөн зуу/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга Ё.Мөнхбатад даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА.



С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 07 сарын
30 өдрийн 06 -р тогтоолын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Dell Led Crystal дэлгэц	ш	1	350,000	350,000
2	Процессор DDR 4gb 500gb	ш	1	1,299,000	1,299,000
3	LED TV D4OSI	ш	1	899,900	899,900
4	Проектр EPSON	ш	1	1,360,000	1,360,000
5	Проекторын дэлгэц	ш	1	189,900	189,900
6	Зургийн аппарат	ш	1	1,599,000	1,599,000
7	Телефон	ш	1	189,900	189,900
8	Тог баригч	ш	1	180,000	180,000
9	Диктафон	ш	2	109,000	218,000
10	Дүрс бичигч	ш	1	190,000	190,000
11	Камер	ш	1	135,000	135,000
12	Камер	ш	1	220,000	220,000
13	Ширээ	ш	1	765,000	765,000
14	Сандал	ш	7	158,000	1,106,000
15	Хатуу диск	ш	1	185,000	185,000
16	Тэжээлийн блок	ш	1	30,000	30,000
17	Салаалагч	ш	1	28,000	28,000
18	Өлгүүр	ш	2	86,600	173,200
19	Толь	ш	1	11,000	11,000
Нийт дүн					9,128,900